

ТӨВ, ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД ТАРХСАН ТАРИМАЛ УРГАМЛЫН ӨВЧИН, ХӨНӨӨЛТ ШАВЬЖ, ХОГ УРГАМАЛ, МЭРЭГЧ АМЬТНЫ ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

ГЭРЭЭТ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

УДИРДАГЧ: Доктор, Дэд Профессор М.БЯМБАСҮРЭН

БАГИЙН АХЛАГЧ: Доктор, Б.МӨНХЦЭЦЭГ

СУДЛААЧИД: Доктор, Т. АЗЗАЯА
Доктор Г.МӨНХЧУЛУУН
Докторант А. УРАНЧИМЭГ
Магистрант Б. ЭНХЖАРГАЛ

Төв, Дархан-Уул аймгийн сумдын тариалангийн талбайд тархсан таримлын өвчин, хортон шавьж, хог ургамал, хөнөөлт мэрэгч амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хор хөнөөлийг судлан тогтоох, судалгааны өгөгдлүүдийг мэдээллийн санд оруулах, тэдгээртэй тэмцэх арга технологийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан тариаланчдад зөвлөх зорилгоор судалгааны ажлыг УХЭШХ-ийн судлаачид гүйцэтгэв.

2022 оны байдлаар Төв аймгийн сумдын 54143 га талбайд үр тариа тариалснаас 47512 га талбайд буудай, 1172 га-д арвай, 4859га-д овьёос, тус бүр 120 га талбайд хөх тариа, шар буурцаг, 130 га талбайд гурвалжин будаа, 144 га талбайд вандуй тариалсан байна. Мөн тэжээлийн ургамал 15159 га, тосны ургамал 26029 га, олон наст 10 га талбайд тариалжээ. Төв аймгийн Баяндэлгэр суманд 70 га талбайд үр тариа, үүнээс 50 га талбайд улаанбуудай, 20 га-д овьёос, 370 га ногоон тэжээл, 630 га тосны ургамал тариалсан байна. Тус сумын нутагт 110 га талбайд рапс, 110 га талбайд ногоон тэжээлийн талбайд ажиллав. Архуст суманд 2976 га талбайд үр тариа, үүнээс 1150 га талбайд улаанбуудай, 200 га арвай, 1506 га-д овьёос, 70 га гурвалжин будаа, 2752 га ногоон тэжээл, 2373 га тосны ургамал тариалсан ба судалгаанд 400 га талбай хамрагдав. Баянцогт сумын хэмжээнд 7456 га талбайд үр тариа, үүнээс 7266 га талбайд улаанбуудай, 190 га-д овьёос, 2820 га ногоон тэжээл, 2080 га тосны ургамал тариалснаас улаан буудай тариалсан 500 орчим га талбай судалгаанд хамрагдав. Аргалант сумын хэмжээнд 3325 га талбайд үр тариа, үүнээс 2680 га талбайд улаанбуудай, 175 га-д арвай, 350 га-д овьёос, 120 га хөх тариа, 530 га ногоон тэжээл, 3120 га тосны ургамал тариалсан байна. Нийтдээ 150 га улаанбуудай, рапс 80 га, овьёос 10 га, ногоон тэжээл 200 га нийт 530га талбай судалгаанд хамрагдав.

Эрдэнэсант сумын хэмжээнд 13128 га талбайд үр тариа, үүнээс 12504га талбайд улаанбуудай, 100 га-д арвай, 260 га-д овьёос, шар буурцаг 120 га, вандуй 144 га, 297 га ногоон тэжээл, 860 га тосны ургамал тариалсанаас улаанбуудай 500га, рапс 40 га, вандуй 80 га, шар буурцаг 40 га, ногоон тэжээлийн 200 га судалгаанд хамрагдлаа. Угтаалцайдам сум 5056 га талбайд үр тариа, үүнээс 4730 га талбайд улаанбуудай, 326 га-д овьёос, 631 га ногоон тэжээл, 5399 га тосны ургамал тариалсан байна. Үүнээс 1000 га улаанбуудай, 200 га тэжээлийн ургамлын талбай судалгаанд хамрагдлаа. Сүмбэр сумын 200 га улаанбуудай, 200 га рапс, 180 га ногоон тэжээл тариалсан талбай судалгаанд хамрагдав.

2022 онд Дархан-Уул аймгийн хэмжээнд 14563 га талбайд буудай тариалсан бол 4808га талбайд рапс, 549 га-д ногоон тэжээл, 20 га-д буурцагт ургамал тариалсанаас Хонгор сумын 2000 орчим га буудайн талбайд судалгааны ажлыг гүйцэтгэв.

Төв, Дархан-Уул аймгийн сумдын тариалангийн талбайд тархсан хөнөөлт шавьжийн дээжийг явуулын судалгаа хийж цуглуулан зүйлийн бүрэлдэхүүнийг тогтоох, тархалт, нягтрал хөнөөлийн хэмжээг тодорхойлох судалгааны ажлыг хийв. Үүнд:

1. Хөнөөлт шавьжийн төрөл, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, биологи, экологи (амьдралын цикл, эзэн ургамал гэх мэт)-ийг судлан тодорхойлох, хөгжлийн зэрэг, хор хөнөөлийг тооцох, тарималд үзүүлж буй шинж тэмдгүүдийг тогтоох, тодорхойлох, шинж тэмдгийг харуулсан зургийг хавсаргасан.
2. Ургамлын өвчин үүсгэгчийн овог, төрөл, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, биологи, экологи (амьдарлын цикл, эзэн ургамал гэх мэт)-ийг судлан тодорхойлох,

- хөгжлийн зэрэг, хор хөнөөлийг тооцох, тарималд үзүүлж буй шинж тэмдгүүдийг тогтоох, тодорхойлох, шинж тэмдгийг харуулсан зургийг хавсаргасан.
3. Хог ургамлын төрөл, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, биологи, экологи (амьдралын цикл, эзэн ургамал гэх мэт)-ийг судлан тодорхойлох, хөгжлийн зэрэг, хор хөнөөлийг тооцох, тарималд үзүүлж буй шинж тэмдгүүдийг тогтоох, тодорхойлох, шинж тэмдгийг харуулсан зургийг хавсаргасан,
 4. Тариалангийн талбайн мэрэгч амьтны төрөл, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, биологи, экологи (амьдралын цикл, эзэн ургамал гэх мэт)-ийг судлан тодорхойлох, хөгжлийн зэрэг, хор хөнөөлийг тооцох, тарималд үзүүлж буй шинж тэмдгүүдийг тогтоох, тодорхойлох, шинж тэмдгийг харуулсан зургийг хавсаргасан.
 5. Судалгаанд хамрагдсан талбайд урьд өмнө тохиолдож байгаагүй шинэ төрлийн хөнөөлт организмын тандан судалгааг хийх, шинээр илэрсэн тохиолдолд тэдгээрийн нэвтрэн орж ирсэн арга замыг тодорхойлох, биологи, экологи (амьдралын цикл, эзэн ургамал гэх мэт) хөнөөл учруулах өсөлтийн үе шатыг тодорхойлсон.



Төв аймгийн Хөдөө аж ахуйн газрын хамт олонтой уулзаж, энэ жилийн судалгааны ажлаа гүйцэтгэх чиг үүргийн талаар зөвлөлдсөн.



Тариаланчидтай хамт судалгааны талбарт

ДҮГНЭЛТ

Ургамлын өвчин:

1. 2022 онд Төв, Дархан-Уул аймгийн тариалангийн талбайд хийсэн ургамлын өвчний судалгаагаар буудайн тарималд 3 ангийн, 3 багийн, 4 овогт хамаарах 5 зүйлийн халдварт өвчин, 1 төрлийн халдваргүй өвчин, тосны таримал болох рапсын тарималд 2 зүйл, тэжээлийн ургамал овъёосонд 1 зүйл өвчин илэрснийг бүртгэлээ.
2. Төмс, хүнсний ногооны таримлуудад нийт 4 анги, 6 баг, 6 овогт хамаарах 7 зүйлийн халдварт өвчин бүртгэгдсэнээс төмсний таримал дээр ургалтын хугацаанд мөөгөнцрийн 2 зүйл, вирусийн 1 зүйл өвчин, сонгинын тарималд мөөгөнцрийн 2 зүйл, вирусийн 1 зүйл өвчин байгааг тэмдэглэв.
3. Жимс жимсгэнийн таримлуудад 3 анги, 7 баг, 8 овгийн 8 зүйл өвчин бүртгэгдсэнээс үхрийн нүдний таримлын 3 зүйл, бөөрөлзгөний 2 зүйл, алимны модны 1 зүйл, чацарганын 1 зүйл, хөх далан хальс жимсгэний 1 зүйл өвчин илэрснийг тэмдэглэлээ.

4. Хүлэмжийн таримлуудад 6 анги, 7 баг, 7 овгийн 8 зүйл халдварт өвчин, 1 төрлийн халдваргүй өвчин илэрснийг бүртгэсэн. Хүлэмжийн хэмхийн тарималд 5 зүйлийн мөөгөнцөр, 1 зүйлийн вирусээр өвчилсний зэрэгцээ шим тэжээлийн бодисын дутагдалд орсон байв. Хүлэмжийн лоолийн тарималд 3 зүйлийн мөөгөнцрөөр өвчилсөн байлаа.
5. Бид судалгааны явцад буудайнд түрүүний үзүүр цайх халдваргүй өвчин, сонгинын шар судалт вирусийн өвчин, хүрэн манжингийн церкоспориозийн толбожилт, алимны гуалах болон хөх далан хальсны антракноз зэрэг өвчнийг шинээр бүртгэж, буудайн навчны хүрэн зэв, төмсний фитофтор зэрэг өргөн тархалттай, хор хөнөөл ихтэй зарим өвчнийг онцлон тэмдэглэв.

Хөнөөлт шавьж:

1. **Буудайн** талбайд шавьжийн ангийн 4 багийн **4 зүйл** зүйл, **төмс, хүнсний ногооны** талбайд 4 багийн **9 зүйл**, Аалз хэлбэртний ангийн, Хачгийн багийн **1 зүйл**, Хорхойн ангийн **1 зүйл** тэмдэглэгдлээ.
2. **Жимс, жимсгэнийн талбайд** Шавьжийн ангийн 2 багийн **3 зүйл**, Аалз хэлбэртний Хачгийн багийн **1 зүйл, хүлэмжид** 3 багийн **3 зүйл**, Аалз хэлбэртний Хачгийн багийн **2 зүйл** тэмдэглэлээ.
3. Шинээр хүлэмжид хэмхийн таримал дээр **Улаан хачиг *Tetranychus cinnabarinus*** (*Boisduval*), сонгинын талбайд хөрсний **дугариг хорхой**, буудайн талбайд **Ишний хярга** илрүүлээ.
4. Буудайн түрүүний толгой цайралт талбайн 10-30%-д тохиолдож, шалтгаан нь олон хүчин зүйлтэй холбоотой байна.
5. Шинээр хортны зүйл бүртгэгдэж байгаа тул дотоод хорио цээрийн хяналтын асуудлыг сайжруулах шаардлагатай байна.

Хог ургамал:

1. Төв, Дархан-Уул аймгийн үр тарианы талбайд 16 овгийн 41 төрөл 45 зүйлийн хог ургамал тархсанаас нэг наст хог ургамал 20 зүйл буюу 44,4%, хоёр наст хог ургамал 4 зүйл буюу 8,9%, олон наст хог ургамал 21 зүйл буюу 46,7%-ийг тус тус эзэлж байв.
2. Үр тариа, тосны таримлын талбайд хавар зуны нэг наст 14 зүйл хог ургамал, зун намрын 2 зүйл хог ургамал, өвлийн хог ургамлаас 4 зүйл хог ургамал, хоёр наст 4 зүйл, олон наст үндэслэг иштэй 14 зүйл, үндсээр үрждэг 5 зүйл, голлосон үндэстэй 2 зүйл хог ургамал тархан ургасан.
3. Эрдэнэсант сумын буудайн тариалалт оройтсон, хог ургамлын эсрэг гербицид хэрэглэсэн боловч 3-4 баллын хогтолтын түвшинд, гербицид бордоотой хамт шүршиснээс хог ургамал гербицидийг тэсвэрлэж, буудайн навч хуйларч стресст орсон нь ажиглагдав.
4. Төв аймгийн ихэнх нутгаар өдөртөө халж, шөнөдөө хүйтэрч температурын хэлбэлзлээс шалтгаалан тариан түрүү хайрагдсан байна.
5. Төмс, хүнсний ногооны талбайд 17 овгийн 42 төрөл 45 зүйлийн хог ургамал тархсанаас нэг наст хог ургамал 23 зүйл буюу 51,1%, хоёр наст хог ургамал 4 зүйл буюу 8,9%, олон наст хог ургамал 18 зүйл буюу 40,0%-ийг тус тус эзэлж байв.
6. Төмс хүнсний ногооны талбайд хавар зуны нэг наст, үндэслэг иштэй олон наст хог ургамлууд тархан хамгийн их хөнөөл учруулж байв.
7. Төвийн бүсийн тариалангийн талбайд дотоод хорио цээртэй Чөдөр тарна, Татаар сагаг, Эгэл ноцоогоно, Хүрэн ягаан нонео зэрэг хог ургамлууд өргөн тархсан.

Хөнөөлт мэрэгч:

1. 2022 онд Төв аймгийн 30,0 мян/га тариалангийн талбайг хамруулан хөнөөлт мэрэгч амьтадын тодотгох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны үр дүнд төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Баянцогт, Аргалант, Баянхангай, Лүн, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр сумын 1,2 мян/га тариалангийн талбайд үлийн цагаан оготнын тархалттай, үүнээс 0,5 мян/га талбайд тэмцэх ажил зохион байгуулах шаардлагатай байна.
2. Төв аймгийн Баяндэлгэр, Архуст, Баянцогт, Аргалант, Баянхангай, Лүн, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Баянчандмань сумдын 1,8 мян/га тариалангийн талбайд монгол чичүүлийн тархалттай, үүнээс 1,2 мян/га талбайд тэмцэх ажил зохион байгуулах шаардлагатай байна.

3. Дархан-Уул аймгийн Хонгор сумын 8,0 мян/га талбайд арга зүйн дагуу судалгааны ажлыг гүйцэтгэснээс 0,5 мян/га талбайд монгол чичүүлийн тархалттай байна. Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын тариалангийн талбайд хөнөөл учруулагч мэрэгч амьтад тархаагүй байна. Судалгааны ажлыг гүйцэтгэсэн тариалангийн талбайд хөнөөлт мэрэгч амьтадын тархалт хор хөнөөлийн балл нь (I)-ээс хэтрэхгүй боловч тохиромжтой орчин бүрдсэн үед богино хугацаанд тархалтын хамрах хүрээ тэлэх, хор хөнөөлийн балл нэмэгдэх хандлагатай байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Ургамлын өвчний талаар: Таримал ургамлын өвчин цаг уурын нөхцөлөөс шалтгаалан жилээс жилд харилцан адилгүй тархдаг. Дулааны улиралд хур тунадас ихээр унах, температурын хэлбэлзэл их байх нь буудайн септориоз, зэв өвчин дэгдэх, буудайн таримал цэцэглэлтийн эмзэг үедээ гэмтэж түрүүний үзүүр цайх зэрэг эмгэгт ихээр өртөж байна. Мөн төмсний таримлын ургалтын үед фитофтор өвчин тархаж, энэ нь цаашид ургацын хэмжээ болон чанарт сөргөөр нөлөөлдөг гол хүчин зүйл болж байна. Ургамал ургалтын хугацаанд хийсэн судалгааны ажлын үр дүнгээр өвчний тархалтаас шалтгаалах ургацын алдагдлыг урьдчилсан тооцоог гаргадаг. Цаашид судалгааны ажлын дүнг баталгаажуулах зорилгоор тухайн сумдын газар тариалангийн мэргэжилтэн нар иргэд аж ахуйдынхаа намрын ургац хураалтын дүнгээс манай судлаачдад ирүүлдэг болбол, бид ургамал ургалтын хугацаанд өвчинтэй тэмцэх арга хэмжээг авсан аж ахуйн ургацыг тэмцэх арга хэмжээ явуулаагүй аж ахуйн ургацтай жиших, мөн тэмцэх арга хэмжээг явуулсан фунгицидийн ургац хамгаалсан хувь хэмжээг тооцоолж тариаланчдад бодитой мэдээлэл хүргэдэг болох үндэслэл болох юм.

Шавьж: Буудайн түрүүн толгой цайралт, гаж дүрс хувирал элбэг тохиолдоцтой байгаа тул өвчин, шавьжийн хөнөөл, пестицид, бордооны хэрэглээний технологи, цаг уурын хүчин зүйлийн нөлөөг нарийвчлан судлах судалгааг 1-2 жил суурин болон явуулын аргаар гүйцэтгэх

2022 оны ургамал ургалтын хугацааны цаг уурын онцлогтой холбоотойгоор 6 сарын сүүлийн арав хоногт говийн бүсийн нутаг Говь-сүмбэрт, 7 сарын эхний арав хоногт Улаанбаатар хот орчимд, 8 сарын сүүлийн арав хоногт Увсын Баруунтуруунд **Нугын бор эрвээхэйн (*Loxostege sticticalis*)** ид олшрол, нүүдэл явагдаж бэлчээр, үр тариа, рапс, хүнсний ногооны талбайд хөнөөл учрууллаа. Энэ зүйл эрвээхэйн тархалт, олшролт, прогнозын судалгааг 1-10 жилийн давтамжтайгаар байнга хийж, ажиглалт мониторинг хийх шаардлагатай байгаа тул төсөл хөтөлбөр, гэрээт ажил хэрэгжүүлэх.

Хог ургамал

- Тариалангийн талбайн хог ургамалтай тэмцэх ургамал хамгааллын талаар тариаланчдад сургалт хийж мэдлэг олгох шаардлагатай байна. Олон жил хог ургамалтай тэмцэх ажлыг гүйцэтгэж байгаа боловч таримал ургамал болон хог ургамлын хөгжлийн үе шатыг тодорхойлох, түүнд тохирсон тун, нормын тохируулах, хэрэглэх, найруулах зэрэг дадал, мэдлэг дутмаг байна.

- Тариалангийн талбайд сэлгээг оновчтой нэвтрүүлэх шаардлагатай байна.

Мэрэгч:

- Тариалалтын үеэс эхлэн хураах хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх ургамал хамгааллын асуудлаар иргэд, тариаланчдад сургалт зохион байгуулах

- Ургамал хамгааллын бодисын хэрэглээ түүнийг зүй зохистой ашиглах хэрэглэх тал дээр баримтлах журмын төсөл эсвэл хуульд заалтаар оруулах (учир нь тухайн жилийн ургамал хамгааллын бодисын жагсаалтад багтаагүй, нэр төрөл өөр худалдаанд нэвтрээгүй төрөл бүрийн бодисыг хэн хүссэн нь хэрэглэж монгол орны биологийн төрөл зүйлийн нөөцөд хор хөнөөл учруулах магадлал өндөр байна.)

- Зарим таримал ургамал нь тариалалтын болон тээвэрлэлтийн алдаанаас үүдэлтэйгээр тариалангийн талбайд хог ургамал болон ургаж байна. Энэ асуудал нь цаашид бэлчээрт хүртэл ургах магадлалтай байгаа учир түүнтэй тэмцэх шаардлагатай байна. (Төв аймгийн Жаргалант сумын тариалангийн талбай орчмоор тосны ургамал маш ихээр тархан жилээс жилд нэмэгдэх хандлаатай байна)

- Иргэд тариаланчид болон ургамал хамгааллын бодис импортлогч нарын дагаж мөрдвөл зохих стандарт боловсруулан дагаж мөрдөх шаардлагатай байна.

СЭЛЭНГЭ, ОРХОН АЙМГУУДЫН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД ТАРХСАН ӨВЧИН, ХӨНӨӨЛТ ШАВЬЖ, ХОГ УРГАМАЛ, МЭРЭГЧ АМЬТДЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ, ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН

УДИРДАГЧ: Доктор, дэд профессор М.БЯМБАСҮРЭН

БАГИЙН АХЛАГЧ: Доктор, дэд профессор Т.ДЭЖИДМАА

СУДЛААЧИД: Доктор дэд профессор Х.БАТНАРАН

Доктор Д.ЦЭВЭЭНДОРЖ

Доктор О.АРИУНАА

Магистр Ж.БАРХАСДОРЖ

Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.10 дахь заалтад заасны дагуу “Тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд судалгаа хийж, дүгнэлт гаргах” зорилгоор “Монгол орны Төвийн бүсийн газар тариалангийн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүн, хөнөөлийг тогтоох судалгаа” сэдэвт зөвлөх тендерийн ажлын хүрээнд Төвийн бүсийн Сэлэнгэ аймгийн үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийн талбайд тархсан өвчин, хортон шавьж, хог ургамал, мэрэгч амьтдын тархалт, зүйлийн бүрэлдэхүүн, хөнөөлийг тогтоох судалгааны ажлыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Сэлэнгэ, Орхон аймгийн нийт 18 суманд ургамал ургалтын хоёрдугаар хагаст явуулын судалгаа хийж тариалангийн талбайд тархсан өвчилсөн ургамал, хөнөөлт шавж, хог ургамал, мэрэгч амьтдын дээжийг цуглуулан тэдгээрийн зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, тархалт, нягтрал, хөнөөлийн хэмжээг тогтоох судалгааны ажлыг гүйцэтгэв. Явуулын судалгааны явцад дараах ажлуудыг хийсэн.

Үүнд:

1. Буудай, хошуу будаа, арвай, төмс, хүнсний ногоо, чацаргана, үхэр нүд, үрэл, бэсрэг алим, алим зэрэг жимс, жимсгэнийн талбайд тархсан өвчин үүсгэгчид, шавьж, хог ургамал, мэрэгч амьтдыг илрүүлэн бүртгэж, дээж цуглуулав.
2. Түгээмэл тархсан хөнөөлт организмын зүйлийн тархалт, хөнөөлийг тогтоож, фото зургаар баталгаажуулав. Фото зургийг талбайд CANON аппарат болон гар утасны камераар авч лабораторид микроскоп, томруулдаг шил ашиглан морфологи, бие бүтцийн хэмжилтийг хийв.
3. Ургамалд өвчин үүсгэгчийг үзүүлсэн гадаад шинж тэмдгээр, хөнөөлт шавьжийн зүйлийг шүүрүүл ашиглах, мод бут доргиох буюу сэгсрэх, дээж авах аргаар, хог ургамлыг гадаад морфологи шинж тэмдгээр, мэрэгч амьтдыг нүх, үлийн байрлал, ялгадас, морфологи шинж тэмдгээр илрүүлэн тооцоо хийж хөнөөлийн хэмжээ, тархалтыг тодорхойлов.
4. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдэд хөнөөлт организмын тухай, тэдгээртэй тэмцэх арга хэмжээ, пестицидийн хэрэглээний талаар зөвлөгөө өгч ажиллав.

Судалгаа хийхийн өмнө аймаг сумдын удирдлага, агроном, мэргэжилтэн нараас санал авч орон нутгийн нийт тариалангийн газрын хэв шинжийг төлөөлөхүйц хэд хэдэн талбайг сонгон судалгааг хийв. Судалгаанд ихэвчлэн аж ахуйн нэгжийн эзэмшил томоохон үр тариа зонхилсон талбай, их, бага хэмжээтэй өрхийн болон хүлэмж, ил талбайн тарималтай талбай хамрагдсан. Судалгаанд Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Жавхлант, Ерөө, Хүдэр, Алтанбулаг, Сүхбаатар, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Хушаат, Сайхан, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Орхон аймгийн Жаргалант сумын (нийт 18 сум) тариалангийн талбай хамрагдсан. Сэлэнгэ, Орхон аймаг нь газар тариалангийн төв бүсэд хамрах бөгөөд олон нэр төрлийн таримал тариалдаг. Таримлын төрлийг 2022 оны байдлаар авч үзвэл буудай, эрдэнэшиш (тэжээлд), рапс, төмс, байцай, шар лууван, хэмх,

лооль, чинжүү, цэцэгт байцай, сонгино, саримс, тарвас, хулуу, арвай, хошуу будаа, вандуй, гурвалжин будаа, хөх тариа, шар манжин, хүрэн манжин, навчит ногоо, чацаргана, үхрийн нүд зэрэг таримал зонхилж байв. Судалгаанд хамрагдсан сумдын үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон хүлэмжид тариалсан таримал бүхий аж ахуйн нэгж, иргэдийн тариалангийн талбайн 55-108 цэг /дээж талбай/-т судалгаа хийв.



Судалгааны багийнхан



Тариаланчдад буудайн талбайд хөнөөлт организм илрүүлэх зөвлөгөө өгч байгаа нь:

ДҮГНЭЛТ

1. Сэлэнгэ аймгийн Мандал сум, Баянгол сум, Жавхлант сум, Ерөө сум, Хүдэр сум, Алтанбулаг сум, Шаамар сум, Сүхбаатар сум, Зүүнбүрэн сум, Түшиг сум, Цагааннуур сум, Хушаат сум, Сайхан сум, Орхон сум, Сант сум, Баруунбүрэн сум, Орхонтуул сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Жаргалант сумд зэрэг Сэлэнгэ аймгийн 17 сум, Орхон аймгийн 2 сум бүгд 19 сумдын тариалангийн газарт мэрэгч, туулайтны тархалт, нягтрал, хөнөөл, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох судалгаа хийв.
2. Бидний судалгаагаар тарималтай газар болон талбай орчимд 12 зүйл мэрэгчтэн, 2 зүйл туулайтан тархсан байна.
3. Сэлэнгэ аймгийн бүх сумдад мэрэгчдээс хэргэлзий оготно, хөх шишүүхэй, орог зузга, гэрийн хулгана, дагуур огдой, боролзон туулай тархдаг байна
4. Сэлэнгэ аймгийн судалгаанд хамрагдсан сумдууд тариалангийн бүс нутаг бөгөөд ойт хээрийн бүсэд хамаарах ба хар шороо, хүрэн хөрс зонхилсон чийглэг уур амьсгалтай, энэ жил хур тунадас их унасан сумдын тариалангийн талбай орчимд байгалийн ургац сайжирснаас мэрэгчид таримал ургамалд хөнөөл учруулаагүй байна.
5. Судалгаанд хамрагдсан дээрх бүх сумдад тариалангийн талбай нь ихэвчлэх уулын нуга, уулын хээрийн чийглэг биотопт орших тул тухайн амьдрах орчныг шүтэн амьдардаг сүүлэрхэг зурам, хэргэлзий оготно, хүрэндүү ойго, шишүүхэйн төрлийн мэрэгчид зонхилон тархсан байна.

6. Түшиг сумын өмнөд хэсэг, Шаамар сумын өмнөд, баруун хэсэг, Алтан булаг сумын баруун ОХУ-ын хил хүртэл баруун хойд хэсэг, Ерөө сумын сумын төв орчим, өмнөд хэсэг, Жавхлант сумын ихэнх нутаг, Цагааннуур сум, Сайхан сум, Орхонтуул сум, Баруунбүрэн сум Орхон аймгийн Жавхлант сумдын нутгийн таримлын талбайгаар тариалангийн талбайн гол хөнөөлт мэрэгч болох хул чичүүлийн тархалттай байна.
7. Баруунбүрэн сумын зүүн, Сайхан сумын номгон баригад, баруун баруун өмнөд хэсгээр Орхон сумын өмнөд хэсэг, Орхонтуул сумын баруун хэсэгт цайвар үлийч тархсан байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

I.Тариаланчдад: Буудайн өвчнөөс урьдчилан сэргийлэх

1. Тариалангийн талбайд ургамал өвчлөх магадлалыг зөв урьдчилан таамаглах нь чухал бөгөөд боломжтой бол ургацын алдагдалд хүрхээргүй түвшинд байлгахыг хичээх хэрэгтэй. Урьдчилан таамаглал нь тухайн талбайн нөхцөл байдлын иж бүрэн дүн шинжилгээ, тодорхой хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурладаг. Эмгэг төрүүлэгчийн хөгжил, цаг агаарын байдалд мониторинг хийх нь чухал.
2. Ургамлыг ажиглах нь өвчнийг хянах, хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх үндэс суурь болдог. Жишээлбэл, буудайн гол хатгах, түрүүлэх (туг навч) үе - үр тарианы ургамлыг өвчнөөс химийн аргаар хамгаалах үр дүнтэй байдлыг тодорхойлох хамгийн чухал үе шат юм. Энэ хугацаанд өвчний хяналтыг өдөр бүр тавих нь зүйтэй.
3. Навчны өвчний халдварын тархалтыг буудайн ургалтын эхний хагасын ус цаг уурын нөхцлөөр тодорхойлдог. Навчны зөв өвчний явц эрчимтэй явагдахад агаарын температур 20-25 хэм байх ба богино хугацааны хур тунадас, нарлаг дулаан өдрүүдээр солигдох нь таатай нөлөөлдөг.
4. Дараах цаг агаарын нөхцөлд септориоз өвчний явц эрчимтэй явагдана: 6-7-р сард, улаан буудайн сүүн болцын үед орох хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 1.5-2 дахин их, харьцангуй чийг 65-70% ба түүнээс дээш, 1 мм-ээс их хур тунадас орсон өдрийн тоо 13-20, агаарын өдрийн дундаж температур 18 хэмээс дээш байх.
5. Байнгын хур тунадастай, агаарын харьцангуй чийг 80%-иас дээш, агаарын температур 15-20 хэмтэй байх цаг агаарын нөхцөлд буудайн навчны 10% -иас дээшид нь септориоз илрэх нь буудайн түрүүг септориозоос хамгаалах шаардлагатай байгааг харуулдаг. Хамгаалах үр дүнтэй аргын нэг бол туг навч гарах үед системийн үйлчилгээтэй фунгицидээр шүрших нь оновчтой байдаг. Шүршилтийг богино хугацаанд (3-4 хоногийн дотор) өглөө, оройн цагаар салхины хурд 5 м / с-ээс ихгүй байхад хийнэ.
6. Түрүүний септориоз нь дараах цаг агаарын нөхцөлд их хэмжээгээр гардаг: ойр ойрхон бороо орох, манан, шүүдэртэй, агаарын харьцангуй чийг 80% -иас дээш, агаарын температур 15-20°C, ургамлын гадаргуу дээр чийг удаан хугацаанд (20-30 цагаас илүү) байх. Өвчний халдварын боломжит (нөөц) үзүүлэлт нь туг навчны 10% -иас илүү нь халдвар авах явдал юм.

II. Хог ургамалтай тэмцэх арга хэмжээ

1. Уриншийн талбайд мөлхөө хиаг, арзгар азаргана, хөдөөгийн шаралзгана, гашуун банздоо, чөдөр сэдэргэнэ, хогийн цангуу, буриад хонин зажлуургана зэрэг хог ургамлууд талбайд жигд ногоорч эхлэх үед Morris, John Deere 2210, Германы Lemken, Лидэр 4, Лидер 6Н, Степняк КС 5.6, Степняк КС 7.6, Bourgault сийрүүлэгчээр 8-10, 12-14 см гүнд сийрүүлэлт хийснээр хог ургамлын үндсийг сайн хэрчихээс гадна бүхэл шороог бутлах, талбайг гадаргууг тэгшлэх, хог ургамлыг хөрснөөс сугалж

гаргаж хатаах замаар тэмцэх арга хэмжээг явуулна. Олон наст үндэслэг иш, үндэсний хэсгээр үржигч хог ургамал тархсан талбайг Спрут –Экстра гербицид (Торнадо, Раундап, Глифосат 500, 540) –ийг хог ургамлын хөгжлийн үе шат, тархалтаас хамааран 1,5-4,0 л тунгаар хэрэглэж болно.

2. Эртийн болон оройн зусах эдгээр хог ургамлууд экологийн хувьд ялгаатай талууд олон байдаг. Тухайлбал эрт цухуйдаг Хонгио хошуу будаа, Цагаан лууль, Чөдөр тарнын үр 1-2⁰С-д соёолдог, 16⁰С-д тохиромжтой, 20⁰С-ээс дээш тохиромжгүй болж соёололт нь зогсдог бол оройн зусах Ногоон хоногбудаа, Зэгэл хоногбудаа, Урвуу гагдайны үр 8-10⁰С-д соёолох боловч 20-24⁰С-д хамгийн тохиромжтой, 42-44⁰С-т соёололт байна. Энэ тохиолдолд эрт цухуйдаг хог ургамлыг устгах зорилгоор тарилтын өмнөх борнойдолт хийх нь зүйтэй. Оройн зусах хог ургамлын төрөл зүйлээс хамааран ургалтын хугацаанд гербицидийг сонгон тэмцэх арга хэмжээг авах хэрэгтэй. Үр тарианы таримлын ургалтын хугацаанд төрөлжсөн гербицид (Пумасупер, Овсюген экспресс, Амазис, Зингер, Фенизан, Дротик, 2,4Д битилийн эфир, 2,4Д флорасулам, Балерина супер, Зерномакс гэх мэт)-ийг зохих заавар, нормын дагуу хэрэглэх хэрэгтэй. Хог ургамал дасан зохицохоос сэргийлж гербицидийн нэр, төрлийг 3-4 жилд сольж хэрэглэх хэрэгтэй.
3. Тухайн аж ахуй нэгжүүд таримлын талбайд тархсан хог ургамлын тархалтын хүрээ, зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчлан тогтоосноор бүс нутагт тохирсон зөв оновчтой тариалах технологийг тарималд бүрд бий болгон мөрдөж, өвчин хортонд тэсвэртэй үрийн материал, сортыг сонгон тариалах, хог ургамлыг экологи, биологитой уялдуулан тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

III. Мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх талаар

1. Сэлэнгэ, Орхон аймагт одоогоор мэрэгчтэнээс цайвар үлийч, хэргэлзий оготно, урт сүүлт зурам, туулайтнаас бор туулай, дагуур огдойноос өөр зүйлийн хөнөөл нь илрээгүй байгаа боловч хил залгаа орших ОХУ-ын нутагт таримал ургамлын хөнөөлт гэж тэмдэглэсэн ижил зүйлийн мэрэгчтэн, туулайтан тархсан байх тул тэдгээрийн, биологи, экологийн онцлог, учруулах хор хөнөөл, авах арга хэмжээний талаар тариаланчид мэдэж байх шаардлагатай байна.

II. Холбогдох салбарын байгууллагад:

1. Улсын үрийн нөөцөд хадгалагдаж байгаа болон ОХУ-аас оруулж ирж байгаа үрийн материалд хог ургамлын үрийн хольц их байгаагаас чөдөр тарна, татар сагаг, чөдөр сэдэргэнэ, хонгио хошуу будаа, хүрэн ягаан нонеоны үр сав баглаа боодол, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр тархалтын хүрээгээ тэлж тариалангийн талбайд тархсаар байна. Ялангуяа 2021-2022 оны хөнөөлт организм илрүүлэх тандан судалгаанаас харахад ОХУ-аас орж ирсэн үрийн улаан буудай, хошуу будааны талбайд татаар сагаг, чөдөр тарна, хонгио хошуу будаа зэрэг дотоод хорио цээртэй хог ургамлын тархалт ихэссээр байна. Үүнд холбогдох мэргэжилтнүүд анхаарч ажиллах хэрэгтэй байна.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ГОВИЙН БҮСИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ӨВЧИН, ХӨНӨӨЛТ ШАВЬЖ, ХОГ УРГАМАЛ, МЭРЭГЧ АМЬТДЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ, ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН

УДИРДАГЧ: Доктор, дэд профессор М.БЯМБАСҮРЭН

БАГИЙН АХЛАГЧ: ШУ-ны Доктор, профессор Н.ЭНХБОЛД

СУДЛААЧИД: Доктор, дэд профессор Б.ДОНДОВ
Доктор И.ОТГОНБААТАР
Доктор Л.БАТДОРЖ
Магистр Г.ГАНЧИМЭГ

Улаанбаатар хот 2022 он

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН ХӨНӨӨЛТ ШАВЬЖИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

Төмс, хүнсний ногооны шавьжийн төрөл зүйл, тархалт, хөнөөлийн судалгаа

Судалгааны хугацаанд төмс, хүнсний ногооны талбайд шавьжийн ангийн 2 багийн 4 зүйл бүртгэв. Үүнд: Тоонолжин цэцэгт таримал дээр байцайны хивэн эрвээхэй *Plutella xylostella* (Linnaeus,1758), сармаг манжингийн цагаан эрвээхэй *Pieris rapae* (Linnaeus,1758), сонгино дээр сонгинын ялаа *Delia antiqua* (Meigen,1826), нугын бор эрвээхэй *Loxostege sticticalis* (Linnaeus.,1761), төмсний таримал дээр сибирийн буглаа цох *Epicauta sibirica* (Pallas.1777) элбэг тохиолдов. Нугын бор эрвээхэйн тархалт шүүрүүлгийн зуу даллалтанд 25-32 бодгаль, 1 ургамал дээрх хүрэнцэр 4-5 ширхэг тоологдож байлаа.



Сармаг манжин, байцайны хивэн, нугын бор эрвээхэйн хүрэнцэр, сонгинын ялааны гэмтээлт гэмтэл

Өмнөговь аймагт төмс, хүнсний ногооны талбайд шавьжийн 2 ангийн 5 багийн 6 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үүнд: Тоонолжин цэцэгт таримал дээр байцайны хивэн эрвээхэй *Plutella xylostella* (Linnaeus,1758), манжингийн цагаан эрвээхэй *Pieris rapae* (Linnaeus,1758), сонгинын ялаа *Delia antiqua* (Meigen,1826), сонгинын үндэсний хачиг *Rhizoglyphus echinopus* (Fumouze & Robin,1868), нугын бор эрвээхэй *Loxostege sticticalis* (Linnaeus.,1761), ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851), энгийн шаргал нүдэн *Chrysopa phyllochroma* (Wesmael. 1841) элбэг тохиолдов. Үүнээс сонгинын ялаа *Delia antiqua* 21.6% тархалттай байв.



Сонгинын ялааны гэмтээлт, нугын бор, байцайны хивэн эрвээхэйн бие гүйцсэн бодгаль

Дорноговь аймагт төмс, хүнсний ногооны талбайд шавьжийн 2 ангийн 6 багийн 9 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үүнд: Байцайны хивэн эрвээхэй *Plutella xylostella* (Linnaeus,1758), манжингийн цагаан эрвээхэй *Pieris rapae* (Linnaeus 1758), сонгинын ялаа *Delia antiqua* (Meigen,1826), сонгинын үндэсний хачиг *Rhizoglyphus echinopus* (Fumouze & Robin,1868), нугын бор эрвээхэй *Loxostege sticticalis* (Linnaeus.,1761), ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851), тоонолжин цэцэгтний хөндийлөгч ялаа *Liriomyza brassicae* (Riley 1885), буглаа цох *Mylabris crocota* (Pallas 1777), судалт

няслуур цох *Agriotes lineatus* (Linnaeus, 1767), тамхины цацаг далавчит (*Thrips tabaci* Lind.), тонолжин цэцэгтний бясаа (*Eurydema gebleri* Kol.) элбэг тохиолдов.



Нугын бор эрвээхэйн хүрэнцэр тонолжин цэцэгтний бясаа, буглаа цох, хөндийлөгч ялааны гэмтээлт, Инсектицид

Говь-Сүмбэр аймагт судалгааны явцад төмс, хүнсний ногооны талбайд шавьжийн ангийн 2 багийн 3 зүйл бүртгэв. Үүнд: Тонолжин цэцэгт таримал дээр байцайны хивэн эрвээхэй *Plutella xylostella* (Linnaeus, 1758), нугын бор эрвээхэй *Loxostege sticticalis* (Linnaeus, 1761), ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851) тохиолдов.



Нугын бор эрвээхэй, хөндийлөгч ялааны авгалдайн гэмтээлт, хивэн эрвээхэйн хүүхэлдэй

Жимс, жимсгэний талбайн шавьжийн төрөл зүйл, тархалт, хөнөөлийн судалгаа

Дундговь аймгийн хэмжээнд энэ онд 15 сумдын нутагт, нийт 9 га талбайд жимс, жимсгэнэ тариалсан. Шавьжийн 2 ангийн 2 багийн 1 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үхэр нүдний нахианы хачиг *Cecidophyopsis ribis* W., 1869, Өрөөсгөл хүр эрвээхэй *Lymintria dispar* L., 1758 тохиолдов.



Өрөөсгөл хүр эрвээхэйн хүүхэлдэйн хоосон гэр, шавьжид нэрвэгдсэн чацарганы бут

Өмнөговь аймгийн хувьд шавьжийн 2 багийн 2 овгийн 2 зүйл бүртгэв. Үүнээс Мушгируулагч бөөс *Rhopalosiphum* sp, Чавганы үрч эрвээхэй *Grapholitha funebrana* T, 1835, тохиолдов.

Иргэн О.Оюунбат жимсний талбайдаа шавьжийн эсрэг бодис цацсан нэрийг нь мэдэхгүй байлаа.



Мушгируулагч бөөсний гэмтээлт, чавганы үрч эрвээхэйн хүрэнцэр

Хүлэмжийн таримлын хортон шавьжийн төрөл зүйл, тархалт, хөнөөл

Дундговь аймгийн хэмжээнд судалгааны явцад хүлэмжид шавьжийн 2 ангийн 2 багийн 1 зүйл, аалз хэлбэртний ангийн 2 зүйл бүртгэв. Үүнд: Ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851), улаан хачиг *Tetranychus cinnabarinus*, хоёр толбот энгийн шүлхий хачиг *Tetranychus urticae* (C.L Koch,1836) тохиолдов.



Энгийн шүлхий хачиг, ногооны хөндийлөгч ялааны гэмтээлт

Өмнөговь аймгийн хувьд шавьж 2 ангийн 2 багийн 1 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үүнд: Ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851) хоёр толбот энгийн шүлхий хачиг *Tetranychus urticae* (C.L Koch,1836), Гуатны бөөс *Aphis gossypii* G.1877, Тоорын бөөс *Myzodes persicae* S.1776 тохиолдов.



Тоорын бөөс, энгийн шүлхий хачиг, ногооны хөндийлөгч ялааны гэмтээлт

Дорноговь аймгийн Сайншанд сум шавьж 2 анги, 2 багийн 2 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үүнд: Ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851), хоёр толбот энгийн шүлхий хачиг *Tetranychus urticae* (C.L Koch,1836), Гуатны бөөс *Aphis gossypii* G.1877, тохиолдов.



Энгийн шүлхий хачиг, гуатны бөөс

Говь-Сүмбэр аймагт Сүмбэр сум шавьжийн 2 ангийн 3 багийн 3 зүйл, аалз хэлбэртний ангийн 1 зүйл бүртгэв. Үүнд: Ногооны хөндийлөгч ялаа *Phytomyza horticola* (Goureau 1851), хоёр толбот энгийн шүлхий хачиг *Tetranychus urticae* (C.L Koch, 1836), Гуатны бөөс *Aphis gossypii* G.1877, Цагаан далавчит *Trialeurodes vaporariorum* W, 1856 тохиолдов.



Цагаан далавчит

Судалгааны хугацаанд 4 аймгийн 24 сумын таримал ургамал дээр нийт шавьжийн 2 ангийн 6 багийн 15 овгийн 19 зүйл, аалз хэлбэртний 3 багийн 3 овгийн 4 зүйл хачиг бүртгэгдэв.

Шавьжийн төрөл зүйл, тэдгээрийн тархалт

Хүснэгт-1

Баг, овог	Төрөл, зүйл	Монгол нэршил
Анги: Шавьж-Hexapoda		
1. Homoptera- Ижил далавчтаны баг		
<i>Aphididae</i>	1. <i>Aphis gossypii</i> G.1877	Гуатны бөөс
	2. <i>Myzodes persicae</i> S.1776	Тоорын бөөс
	3. <i>Rhopalosiphum</i> sp	Мушигируулагч бөөс
<i>Cicadellidae</i>	4. <i>Cicadella</i> sp.	Ногоон цикад
2. Hemiptera- Хагас хатуу далавчтаны баг		
<i>Pentatomidae</i>	1. <i>Eurydema gebleri</i>	Тоонолжин цэцэгтний бясаа
<i>Aleyrodidae</i>	1. <i>Trialeurodes vaporariorum</i> W, 1856	Цагаан далавчит
3. Coleoptera-Хатуу далавчтаны баг		
<i>Meloidae</i>	1. <i>Epicauta sibirica</i> P.1777	Сибирийн буглаа цох
	2. <i>Epicauta megaloccephalo</i> G.1817	Хар толгойт буглаа цох
<i>Elateridae</i>	3. <i>Agriotes lineatus</i> (Linnaeus, 1767)	Судалт няслуур цох
4. Lepidoptera-Хайрсан далавчтаны баг		
<i>Plutellidae</i>	1. <i>Plutella xylostella</i> , (Linnaeus, 1758)	Байцайны хивэн эрвээхэй
<i>Noctuidae</i>	2. <i>Mamestra brassicae</i> L., 1758	Байцайны бүгэг эрвээхэй
<i>Crambidae</i>	3. <i>Loxostege sticticalis</i> L., 1761	Нугын бор эрвээхэй
<i>Tortricidae</i>	4. <i>Grapholitha funebrana</i> T, 1835	Чавганы үрч эрвээхэй
<i>Erebidae</i>	5. <i>Lymntria dispar</i> L., 1758	Өрөөсгөл хүр эрвээхэй
5 Neuroptera- Торон далавчтаны баг		
<i>Chrysopidae</i>	1. <i>Chrysopa phyllochroma</i> (Wesmael. 1841)	Энгийн шаргал нүдэн
6. Diptera – Хос далавчтаны баг		

<i>Anthomyiidae</i>	1. <i>Delia antiqua</i> M, 1826	Сонгинын ялаа
	2. <i>Pegomyia betae</i> C. 1847	Манжингийн жим ялаа
<i>Agromyzidae</i>	3. <i>Liriomyza brassicae</i> Riley 1885	Тоонолжитны хөндийлөгч ялаа
	4. <i>Liriomyza sp</i>	Ногооны хөндийлөгч ялаа
Анги: Аалз хэлбэртэн-Arachnida		
1. Sarcoptiformes-бар		
<i>Acaridae</i>	1. <i>Rhizoglyphus echinopus</i> , (Fumouze & Robin, 1868)	Сонгинын үндэсний хачиг
2. Arachnida- бар		
<i>Eriophyidae</i>	1. <i>Cecidophyopsis ribis</i> W., 1869	Үхэр нүдний нахианы хачиг
3. Trombidiformes-бар		
<i>Tetranychidae</i>	1. <i>Tetranychus urticae</i> , (C.L Koch, 1836)	Хоёр толбот энгийн шүлхий хачиг
	2. <i>Tetranychus cinnabarinus</i>	Улаан хачиг

УРГАМЛЫН ӨВЧНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛ ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

Төмс, хүнсний ногооны өвчний төрөл зүйл, тархалт, хөнөөл

Төмс, хэмх, лооль, чинжүү, бөөрөнхий байцай, цэцэгт байцай, газрын алим, хулуу, артишок, шар манжин, хүрэн манжин, лууван, сонгино, саримс, таван салаа, тарвас, үхрийн нүд, алим, чацаргана зэрэг таримлын өвчний судалгааг арга зүйн дагуу хийж гүйцэтгэхийн зэрэгцээ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга болон хамгаалах Фитоспорин-М биологийн бэлдмэлийг найруулах, ажлын уусмал бэлтгэх, ургамалд шүрших аргыг нэг бүрчлэн зааварлан таницлах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, үрийн материалын ариутгалыг хэрхэн хийх, үр ариутгалын үр өгөөжийг тайлбарлан зөвлөж ажиллав.



Тарвасны антракноз, Төмсний фитофтор

Дундговь аймгийн таримал ургамалд илэрсэн өвчний тархалт, хор хөнөөл 2022 он

Хүснэгт 2

№	Сумын нэр	Таримал	Ургамлын өвчний нэршил	Өвчний тархалт, %	Өвчлөлтийн дундаж балл	Ургацын алдагдал, %
1	Адаацаг	Лооль	Альтернариоз	8.2	1	4.6
			Атираатах вирус	51.4	2	-
		Үхрийн нүд	Хлороз	2.9	1	-
			Алим	Цахлай	3.1	1
2	Эрдэнэдалай	Төмс	Фитофтор	10.2	1	5.25
		Төмс	Фитофтор	8.6	1	3.75
3	Мандалговь Сайнцагаан	Тарвас	Хуурмаг гуалах	13.9	2	9.1
			Антракноз	9.8	2	7.5
		Хэмх	Хуурмаг гуалах	11.6	2	8.1
		Лооль	Альтернариоз	12.3	2	6.2
			Вирус	72.5	2	-
Чацаргана	Мод хатах	62.4	3	75.0		

Өмнөговь аймгийн Баяндалай сумд тариалсан Сэлэнгэ-5 сортын төмсний булцуунд энгийн цахлай өвчин 75-80% тархсан нь сэлгээгүй давтан төмс тариалсантай холбоотой байна. Селист сортын төмсөнд фитогтор, вирусийн навч цоохортох өвчин давамгай тархсан байна.

Даланзадгадын Хаяагийн голд шинээр тарьсан жимсний модонд мөөгөнцрийн өвчин нэлээд тархсан нь суулгацын материалаар халдварласан байна.



Төмсний булцууны энгийн цахлай



Төмсний навч цоохортох вирус, хэмхийн цагаан илжрэл, тарвасны антракноз



Хэмхийн хуурмаг гуалах



Төмсний альтернариоз




Тарвасны фузариоз

Өмнөговь аймгийн таримал ургамалд илэрсэн өвчний тархалт, хор хөнөөл 2022 он
Хүснэгт 3

№	Сумын нэр	Таримал	Ургамлын өвчний нэршил	Өвчний тархалт, %	Өвчлөлтийн дундаж балл	Ургацын алдагдал, %
1	Баяндалай	Төмс	Фитофтор	10.2	1	8.6
			Альтернариоз	28.1	2	19.4
			Вирус/навч цоохортох/	35.2	2	-
			Энгийн цахлай	75	4	68.4
2	Булган	Лооль	Альтернариоз	26.5	2	8.6
			Фитофтор	19.2	2	10.1
		Тарвас	Антракноз	29.8	2	15.4
			Фузариоз	21.6	2	11.8
		Хэмх	Антракноз	11.3	1	7.2
		Амтат гуа		10.7	1	5.8
3	Далан задгад	Төмс	Альтернариоз	18.6	2	6.1
		Лооль	Фитофтор	9.7	1	3.8
		Хурган гуа	Хуурмаг гуалах	8.2	1	2.8
		Гүзээлзгэнэ	Цагаан толбожилт	6.8	1	4.75
		Чавга	Нүхлэг толбожилт	9.2	1	4.4
		Алим	Цахлай	8.4	1	5.0
		Үхрийн нүд	Хлороз	11.6	1	6.2
		4	Цогтцэций	Төмс	Вирус	12.3
Фитофтор	15.2				2	9.4
Альтернариоз	13.6				2	7.9
Өргөст хэмх	Гуалах			12.6	2	10.2
5	Ханбогд	Төмс	Фитофтор	9.8	1	5.3
			Альтернариоз	8.7	1	4.7
		Тарвас	Антракноз	20.2	2	11.6
			Фузариоз	18.7	2	9.5
6	Манлай	Лооль	Фитофтор	10.6	1	8.6
		Хэмх	Өнцгөн толбожилт	7.4	1	3.9
			Цагаан илжрэл	6.8	1	3.4
		Тарвас	Хуурмаг гуалах	7.2	1	3.9
		Төмс	Навч цоохортох	13.4	1	-
			Альтернариоз	10.6	1	5.1



Төмсний фитофтор Таван салааны гуалах Гүзээлзгэний цагаан толбожилт



Лоолийн навч цоохортолт Сонгинын зэв Тарвасны фузариоз



Тарвасны хуурмаг гуалах, Төмсний альтернариоз



Хэмхийн цагаан илжрэл, хуурмаг гуалах


Дорноговь аймгийн таримал ургамалд илэрсэн өвчний тархалт, хор хөнөөл 2022 он

Хүснэгт 4

Сумын нэр	Таримал	Ургамлын өвчний нэршил	Өвчний тархалт, %	Өвчлөлтийн дундаж балл	Ургацын алдагдал, %
Мандах	Төмс	Фитофтор	9.4	1	4.0
Сайхан дулаан	Гүзээлзгэнэ	Цагаан толбожилт	8.2	1	2.9
Сайншанд	Хэмх	Хуурмаг гуалах	8.2	1	3.0
		Өнцгөн толбожилт	8.6	1	3.9
		Цагаан илжрэл	11.2	1	5.4
	Лооль	Фитофтор	10.6	1	4.2
		альтернариоз	9.7	1	2.4
		Навч цоохортох /вирус	12.8	1	-
	Сонгино	Зэв	11.6	2	7.4
	Тарвас	Хуурмаг гуалах	58.4	3	35.1
		Фузариоз	62.8	3	49.7
Амтат гуа	альтернариоз	9.7	1	2.8	

Айраг	Хэмх	Хуурмаг гуалах	8.6	1	2.3
Далан жаргалан	Сонгино	Зэв	10.8	1	4.2
	Төмс	Альтернариоз	12.5	1	5.8
		Фитофтор	15.2	1	6.2
	Хэмх	Антракноз	9.4	1	2.6
	Байцай	Альтернариоз	8.6	1	2.5
	Лооль	Фитофтор	10.3	1	4.1
	Тарвас	Фузариоз	18.5	2	7.5
		Хуурмаг гуалах	17.4	2	8.4

Ил талбайн таримлын нэлээд нь мөндөрт цохигдсон байна. Шивээ говь сумын услалтын системийн 7.5га талбайд тариалсан төмсний булцууг тариалахын өмнө Манкоцеб фунгицидээр ариутган тариалсан, ургалтын үеийн мөөгөнцрийн өвчин илрээгүй байв.



Лоолийн вирусийн өвчин

Говь-Сүмбэр аймгийн таримал ургамалд илэрсэн өвчний тархалт, хор хөнөөл 2022 он
Хүснэгт 5

№	Сумын нэр	Таримал	Ургамлын өвчний нэршил	Өвчний тархалт, %	Өвчлөлтийн дундаж балл	Ургацын алдагдал, %
	Шивээговь	Лооль	Альтернариоз	12.8	1	4.8
	Сүмбэр	Лооль	Альтернариоз	9.8	1	2.9
			Навч цоохортох вирус	13.4	1	-

Төмс, хүнсний ногооны өвчин үүсгэгчдийн ангилал зүй

Хүснэгт 6

Сумын нэр	Таримал	Өвчний нэр	Анги	Баг	Овог	Төрөл зүйл
Адаацаг	Лооль	Фитофтор	<i>Oomycota</i>	<i>Peronosporales</i>	<i>Peronosporaceae</i>	<i>Phytophthora infestans</i>
		Альтернариоз	<i>Dothideomycetes</i>	<i>Pleosporales</i>	<i>Pleosporaceae</i>	<i>Alternaria alternata</i>
		Атираатах	-	<i>Potyviriidae</i>	<i>Potyvirus</i>	<i>Potato virus Y</i>
	Алим	Цахлай	<i>Dothideomycetes</i>	Pleosporales	Venturiaceae	<i>Venturia inaequalis</i>
Эрдэнэ далай	Төмс	Фитофтор	<i>Oomycota</i>	<i>Peronosporales</i>	<i>Peronosporaceae</i>	<i>Phytophthora infestans</i>
Сайн цагаа	Лооль	Фитофтор	<i>Oomycota</i>	<i>Peronosporales</i>	<i>Peronosporaceae</i>	<i>Phytophthora infestans</i>
		Цоохортох	-	<i>Potyviriidae</i>	<i>Potyvirus</i>	<i>Potato virus Y</i>

	Төмс	Фитофтор	<i>Oomycota</i>	<i>Peronosporales</i>	<i>Peronosporaceae</i>	<i>Phytophthora infestans</i>
		Цоохортох	-	<i>Potyviridae</i>	<i>Potyvirus</i>	<i>Potato virus Y</i>
	Хэмх	Хуурамч гуалах	Oomycetes	Oomycete	Peronosporaceae	<i>Peronospora destructor</i>
	Тарвас	Антракноз	<i>Sordariomycetes</i>	Glomerellales	Glomerellaceae	Colletotrichum orbiculare
		Хуурмаг гуалах	Oomycetes	Oomycete	Peronosporaceae	<i>Peronospora destructor</i>
	Чацаргана	Мод хатах	<i>Sordariomycetes</i>	<i>Hypocreales</i>	<i>Inserta sedis</i>	<i>Verticillium dahliae</i>

ХОГ УРГАМЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

Төмс, хүнсний ногооны талбайд тархсан хог ургамлын төрөл зүйл, тархалт, хөнөөл

Дундговь аймгийн Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Адаацаг, Эрдэнэдалай, Мандалговь хот, Сайнцагаан зэрэг сумдад судалгааны ажил гүйцэтгэлээ.

Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр аймгуудын тариалангийн талбайд тархсан хог ургамлын жагсаалт

Хүснэгт 7

Д/Д	Овог	Төрөл	Зүйл	Биологийн бүлгийн ангилал		
				Нэг наст	Хоёр наст	Олон наст
1	Үетэн Poaceae	Хоног будаа <i>Setaria viridis</i> R.B.	Ногоон хоног будаа <i>Setaria viridis</i> P.	+		
		Хошуу будаа	Хонгио хошуу будаа <i>Avena fatua</i> L.	+		
		Хиаг	Мөлхөө хиаг <i>Agropyron repens</i> L6			+
2	Тарна <i>Polygonaceae</i> R.B. L	Тарна <i>Polygonum</i> L.	Чөдөр тарна <i>Polygonum convolvulus</i> L.	+		
3	Гагадай <i>Amaranthaceae</i> Juss	Лууль <i>Chenopodium</i> L.	Цагаан лууль <i>Chenopodium album</i> L.	+		
			Шоргор лууль <i>Chenopodium acuminatum</i> Willd.	+		
			Навчирхаг лууль <i>Chenopodium foliosum</i> (Meonch)Aschers	+		
		Хамхуул <i>Corispermum declinatum</i>	Өнхрүүш хамхуул <i>Corispermum declinatum</i> Steph	+		
		Бударгана <i>Salsola collina</i> L	Толгодын бударгана <i>Salsola collina</i> Pall.	+		
		Гагадай <i>Amaranthaceae</i>	Урвуу гагадай <i>Amaranthus retroflexus</i> L.	+		
4	Сэдэргэнэ <i>Convolvulaceae</i>	Сэдэргэнэ <i>Convolvulus</i> L.	Чөдөр сэдэргэнэ <i>Convolvulus arvensis</i> L.			+
		Азаргана <i>Cirsium mill</i>	Арзгар азаргана <i>Cirsium arvense</i> L.			+
		Шаралзгана	Хөдөөгийн шаралзгана			+

5	Нийлмэл цэцэгтэн Asteraceae Dum	Sonchus L.	Sonchus arvensis L.			
		Шарилж Artemisia L.	Царвант шарилж Artemisia Sieversiana Wild.		+	
			Ишгэн шарилж Artemisia dracunculus L.			+
6	Буурцагтан Fabaceae Lindl	Тарваган шийр Thermopsis danurica	Дагуур тарваган шийр Thermopsis danurica Czeffr.			+
		Гиш	Хулганын (чөдөр) гиш V.Cracca L.			+
7	Таван салаа Plantaginaceae Juss.	Таван салаа Plantago	Их таван салаа Plantago major L.			+
8	Хотир Zygophyllaceae R.Br.	Зангуу	Зэлэн зангуу Tribulus terrestris L.	+		
9	Жамба Malvaceae Juss	Жамба	Могилевын жамба цэцэг Malva mohileviensis Downer	+		
10	Шүхэртэн Ariaceae Lindl	Гоньд	Өндөр үхэр гоньд Spatholobos suberectus K.Pol.		+	
11	Байцай Brassicaceae Burnelt	Байцаа	Зэрлэг байцай Brassica campestris L.	+		
12	Ороонго Cuscutaceae Dumort	Ороонго	Нангиад ороонго Cuscuta chinensis Lam	+		

Өмнөговь аймгийн Даланзадгад хотын 1м² талбайд сонгино, царгасанд, Өмнөговь аймгийн Булган сумын хүнсний ногооны талбайн захад царван, цагаан лууль зэрэг хог ургамлыг ороон гадаад хорио цээртэй шимэгч хог ургамал болох (шар) Нангиад ороонго-*Cuscuta chinensis* Lam 40 м²талбайд ургасан байсныг шинээр тэмдэглэлээ.



Нангиад ороонго-*Cuscuta chinensis* Lam царгас, сонгиныг ороон шимэгчилж ургасан байдал



Нангиад ороонго-*Cuscuta chinensis* Lam хүнсний ногооны талбайн захад Царван, цагаан лууль зэрэг хог ургамлыг ороон шимэгчилж ургасан байдал

ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТДЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ ТАРХАЛТ, ХӨНӨӨЛИЙН СУДАЛГАА

Төмс, хүнсний ногооны талбайд тархсан мэрэгчдийн төрөл зүйл, тархалт, хөнөөл

Дундговь аймагт таримлын талбайн захаар болон бэлчээрт *Lasiopodomys brandtii* -Үлийн цагаан оготны тархалттай байна. 1- га талбайд 9-18 нүх тоологдож байгаа нь, хөнөөлт мэрэгч амьтадын тоо, толгойн нягтшил сийрэг байгааг илчилж, таримлын талбайд таримал ургамлуудад үзүүлэх нөлөө, хор, хөнөөлийн хэмжээ мөн бага зэрэг түвшинд байгааг харуулж байна.



Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумдын төмс, хүнсний ногооны талбайн тариалалт.

Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Ханбогд сум болон Манлай сумдад төмс, хүнсний ногооны таримлын захаар **Шар чичүүл-*Meriones meridianus*, Монгол чичүүл-*Meriones Unguiculatus*, хөхшишүүхэй-*Cricetulus brabensis*, Бозлог зурам -*Citellus erythrognus***, зэрэг мэрэгч болон туулайтан амьтдын тархалт байгаа боловч тарималд үзүүлэх нөлөө, хөнөөлийн түвшинд хүртэл хор, нөлөө үзүүлээгүй, байгаль дээр байх ёстой тоо хэмжээндээ байна. Нэг га талбайд ойролцоогоор 3-6 ширхэг үлий тоологдож, Үлий тус бүрд 2-5 нүх тоологдож байна. Таримлын талбайн захаар болон бэлчээрт 1- га талбайд 10-15 нүх тоологдож, хөнөөлт мэрэгч амьтадын таримлын талбайн ургамлуудад үзүүлэх нөлөө, хор, хөнөөлийн хэмжээ бага, тархалт хэмжээ их ч, тоо, толгойн нягтшил сийрэг байгааг илчилж, хөнөөлийн түвшинд хүрээгүй байгааг харуулж байна.



Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын хөнөөлт мэрэгч Монгол чичүүл-*Meriones Unguiculatus*

болон Монгол огдой /Үхэр/ *ochotona pallasi*-н нүх, үлийний нягтшилын зураг Дорноговь аймгийн Мандах сум, Сайхандулаан сум, Айраг сум, Их-Хэт сум, Даланжаргалан сум, Сайншанд сумуудад хөнөөлт мэрэгч амьтдын тархалттай боловч хөнөөл учруулах хэмжээ бага байна.

Говь-сүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр сумдын нутагт тархсан хөнөөлт мэрэгчдийн төрөл зүйлүүдээс Монгол чичүүл-*Meriones Unguiculatus* тархсан байна. Тариалсан төмс, хүнсний ногооны таримлын болон ил талбайн тарималд хөнөөл учруулж, үзүүлэх хор, хөнөөлийн хэмжээ их биш байна. Судалгааны явцад /хөнөөлт организм/-ын хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх аргазүйн талаар төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдэд зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж ажилласан.



Говь-сүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр сумдын мэрэгчдийн хөнөөлд өртсөн төмс, хүнсний ногооны талбай.

Жимс, жимсгэний талбайд тархсан мэрэгчдийн төрөл зүйл, тархалт, хөнөөл Дундговь аймгийн төв Мандалговь хотод “Гу-Яан Хотын Төгөл”-1,2 - дүгээр талбайн ойн төгөлд Шархуайс, Голтбор, Чацарганы модны иш, нахиа, нарийн мөчрийг туулайтан болон Бор туулай –*Lepus tulai* мэрж идсэн байна.



Мандалговь хотын “Гу-Яан Хотын Төгөл”- ийн мэрэгчдэд идүүлсэн болон өвчилсэн жимс, жимсгэний моднууд

Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Цогтцэций сум, Ханбогд сум, Манлай сум. Бозлог зурам- *Citellus erythrognus*, Хөх-шишүүхэй-*Cricetulus brabensis*, Монгол чичүүл-*Meriones Unguiculatus* зэрэг мэрэгчид, Бор туулай –*Lepus tulai* болон Үхэр-огдой-*Ochotona pallasi* зэрэг туулайтан бага хэмжээтэй тархаж, Ил талбайн таримлын ургалтын үед таримлын нахиа, найлзуур, залуу модны мөчир, иш, үндсэнд хөнөөл учруулж байна.

Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан сумдын ил талбай, Сайншанд сумдын “**Зээгийн хөтөл**”-ийн ил талбайн таримал болон жимсний таримлын талбайд Алагдаага-*Allactaga bullata*, Бозлог зурам - *Citellus erythrognus*, Хөх-шишүүхэй- *Cricetulus brabensis*, Монгол чичүүл-*Meriones Unguiculatus* бага хэмжээтэй тархаж, ил талбайн таримлуудын иш, үндэс, навчыг идэж таримлуудад хөнөөл учруулж байна. Тус аймгийн Эрдэнэ сум, Даланжаргалан сум, Их-Хэт сум, Айраг сумдын Жимс, жимсгэнийн модны талбай болон ил таримлын талбайд Хөх-шишүүхэй- *Cricetulus brabensis*, Монгол чичүүл-*Meriones Unguiculatus* зэрэг мэрэгчид, Бор туулай *Lepus tulai* болон Үхэр-огдой-*Ochotona pallasi* зэрэг туулайтан бага хэмжээтэй тархаж, жимсний модонд учруулах хөнөөлийн хэмжээ, үзүүлэх нөлөө бага байна.



Дорноговь аймаг хөнөөлт мэрэгчид тархсан жимс, жимсгэнийн талбай.



Говь-Сүмбэр аймаг хөнөөлт мэрэгч туулайтан тархсан жимс, жимсгэний талбай.

Хүлэмжид тархсан мэрэгчдийн төрөл зүйл, тархалт, хөнөөл

Говь-Сүмбэр аймагт Сүмбэр сум болон Шивээговь сумдад хүлэмжний тариалалт эрхэлж байгаа газруудын гаднах хашаан дахь ил талбайн таримлын захаар Бор туулай-*Lepus tulai* болон Монгол огдой-*Ochotona pallasii* зэрэг туулайтан, Хөх-шишүүхэй-*cricketulus brabensis*, Монгол чичүүл-*Merionus Unguiculatus* зэрэг мэрэгчид, бага хэмжээтэй тархаж, хүлэмжний талбайн таримлыг ургалтын үед **таримлын үр суулгацыг идэж, хөнөөл учруулж** байна.



Говь-Сүмбэр аймгийн Шивээговь, Сүмбэр сумдын мэрэгчдэд идэгдсэн үр суулгацтай хүлэмж.